



## КОМПАНИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү баримт бичгийг Монгол Улсын Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексын заалтад нийцүүлэн боловсруулав.
- 1.2 Энэхүү бодлогын зорилго нь Бодь Даатгал ХК (цаашид “компани” гэх )-ийн татвар төлсөний дараахь цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах харилцааг зохицуулахад оршино.

### Хоёр. Ногдол ашгийн зарчим

Компани татвар төлсөний дараахь цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилахдаа дараахь зарчмыг баримтлана.

- 2.1 Ногдол ашиг төлсөний дараа компани төлбөрийн чадвартай байх;
- 2.2 Ногдол ашиг төлсөний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;
- 2.3 Компани эргүүлэн авах үүрэг хүлээсэн үнэт цаасаа бүрэн авсан байх

### Гурав. Ногдол ашиг тодорхойлох үйл явц

- 3.1 ТУЗ нь компанийн жилийн эцсийн санхүүгийн үр дүнд үндэслэн ногдол ашиг хуваарилах эсэхийг шийдвэрлэнэ.
- 3.2 Компани нь ногдол ашиг хуваарилахдаа Компанийн тухай хууль, холбогдох журамд заасан нөхцөл шаардлагыг хангасан байна.
- 3.3 Ногдол ашиг төлөх хэлбэр ба хугацаа нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн байх ба хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын баталсан журам, заавар зөвлөмжийг харгалзана.
- 3.4 Ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон тооцооллыг ТУЗ гаргана. Тооцооллыг гүйцэтгэх удирдлага гүйцэтгэж, ТУЗ-ийн Аудитын хороо хянаж, саналыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлнэ.
- 3.5 ТУЗ-аас ногдол ашгийг төлөх өдрийг тогтоохдоо компанийн бизнес төлөвлөгөөтэй

уялдуулан боломжит хугацааг харгалзана.

#### **Дөрөв. Бусад**

4.1 Компани нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг хугацаанд нь төлөөгүй тохиололд хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх ба компанид учирсан хохирлыг гүйцэтгэх захирал хариуцна.

4.2 Энэхүү бодлогын нэмэлт өөрчлөлтийг Төлөөлөн удирдах зөвлөл батлана.